

ИХ БРИТАНИЙН ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЛААРХ ЛАВЛАГАА

Г.Билгээ, Р.Нургүл, Ц.Элбэгзаяа

ИХ БРИТАНИЙН ЗАСГИЙН ГАЗАР²⁶²

Засгийн газрын кабинет нь сонгуульд ялалт байгуулсан намын гишүүдээс бүрдэх ба Парламентын доод танхимд үйл ажиллагаагаа тайлагнана.

Кабинетийн дотоод бүтцийн хувьд Ерөнхий сайд болон бусад гишүүдийг салгаж ойлгоно. Ерөнхий сайд Засгийн газрын үйл ажиллагааг удирдан, Кабинетийн бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, сайд нарыг сонгох, цаашлаад шаардлагатай тохиолдолд Кабинетийг тараах эрхтэй цорын ганц улс төрийн субъект юм.

Парламентын сонгуулийн дараах үйл явц²⁶³

Хэрэв сонгуулийн дараа эрх барьж байсан нам нь бусад намуудын нийт суудлын тооноос илүү суудал авч парламентад дахин олонхыг (majority) бүрдүүлсэн бол одоогийн Засгийн газар үйл ажиллагаагаа хэвийн явуулна.

Хэрэв өөр нам олонхын суудал авсан бол Ерөнхий сайд, Засгийн газар нэн даруй огцрох ба Хатан хаан нь сонгуульд ялсан намын даргатай Засгийн газар байгуулах талаар зөвшилцөнө.

Хэрэв сонгуульд нэг нам олонхын саналыг авч чадаагүй бол шинэ Ерөнхий сайдыг томилж Засгийн газрыг бүрдүүлэх хүртэл одоогийн Ерөнхий сайд, Засгийн газар хэвээр ажиллана.

Аль нэг нам олонхыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд улс төрийн намууд хэн нь Нийтийн танхимын итгэлийг хамгийн сайн хүлээх болон Засгийн газраа бүрдүүлж чадах талаар хэлэлцүүлэг явуулахыг хүсч болно. Энэ тохиолдолд Хатан хаан ямар нэгэн хэлэлцээрт оролцохгүй.

Хэрэв аливаа хэлэлцээрт оролцсон улс төрийн намуудын удирдагчид Төрийн албаны дэмжлэг авах хүсэлтэй бол түүнийг зөвхөн Ерөнхий сайдын зөвшөөрлөөр Засгийн газрын танхимын ажлын алба (Cabinet Secretary with the authorisation of the Prime Minister) зохион байгуулна. Төрийн алба нь зохих журмын дагуу зөвлөгөө өгнө.

Сонгуулийн дараа Засгийн газрын танхим нь итгэл даах чадвартай эсэх талаар эргэлзээтэй байгаа бол Засгийн газрын үйл ажиллагаанд тодорхой хязгаарлалт тавина.

²⁶²Ч.Энхбаатар, С.Зульфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶³The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

Засгийн газрын нөхцөл байдал улс төрийн намуудын хэлэлцээрээс хамаарна. Аль нэг нам олонхыг бүрдүүлж чадаагүй тохиолдолд Засгийн газрыг байгуулах үндсэн 3 хэлбэр байдаг:

- нэг намын, цөөнхийн засгийн газар
- намуудын албан ёсны хэлэлцээрээр
- эвслийн засгийн газар.

Ерөнхий сайдыг томилох

Ерөнхий сайдыг Хатан хаан томилохдоо дараах шалгуурыг баримтлана.²⁶⁴ Үүнд:

- Ерөнхий сайдад нэр дэвшигч нь Парламентын Доод танхимын гишүүн байх;
- нэр дэвшигчийг Парламентын сонгуульд ялалт байгуулсан намын дарга мөн болохыг намын удирдах зөвлөл албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байх (энэ нь гол шалгуур байна);
- улс төрийн үйл ажиллагаа явуулах нөхцлөөр бүрэн хангагдсан байх.

Хатан хаан өөрийн гол зөвлөхийн хувьд одоогийн Ерөнхий сайдаас дараагийн Ерөнхий сайдад хэнийг нэр дэвшүүлэх, хэн Нийтийн Танхимын итгэлийг хүлээх талаар зөвлөмж авч болно.²⁶⁵

Засгийн газрыг бүрдүүлэх

Ерөнхий сайд нь бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газраа бие даан бүрдүүлнэ.²⁶⁶ Засгийн газрыг бүрдүүлэх асуудлаар Хатан хаан нь сонгуульд ялалт байгуулсан намын даргатай зөвшилцөнө.

Ерөнхий сайд болон Засгийн газар огцрох

Хэрэв Ерөнхий сайд нь Засгийн газрын нэрийн өмнөөс огцорвол, Хатан хаан Төлөөлөгдийн Танхимын итгэлийг хамгийн ихээр хүлээж чадах хүнийг Ерөнхий сайдаар ажиллахыг урина.²⁶⁷

Хэрэв Ерөнхий сайд өөрийн хүсэлтээр албан үүргээсээ чөлөөлөгдөж байгаа бол нам, эсхүл засгийн эрхийг барьж буй намууд залгамжлагчийг тодорхойлно. Парламентын доод танхим буюу Нийтийн Танхим нь Засгийн газарт итгэл үзүүлээгүй тохиолдолд Засгийн газар бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорно.²⁶⁸

²⁶⁴Ц.Энхбаатар, С.Зүлфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶⁵The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

²⁶⁶Ц.Энхбаатар, С.Зүлфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

²⁶⁷The Cabinet Manual (A guide to laws, conventions and rules on the operation of government). Cabinet Office 70 Whitehall London. 1st edition October 2011. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/60641/cabinet-manual.pdf

²⁶⁸Ц.Энхбаатар, С.Зүлфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.

Мөн Ерөнхий сайд нь бүрэн эрхийнхээ дагуу Засгийн газрын гишүүдийг албан үүргээс нь чөлөөлнө.²⁶⁹

Хэрэв Засгийн газар нь итгэл үзүүлээгүй бол 14 хоногийн дотор Нийтийн Тамхимаас үүрэг гүйцэтгэж байгаа Засгийн газартай ижил бүтэц, бүрэлдэхүүнтэй альтернатив Засгийн газрыг байгуулж болно. Эсхүл үүрэг гүйцэтгэж байгаа Засгийн газар нь Нийтийн Танхимаас дахин итгэл хүлээлгэх талаар ажиллаж болно.

Хэрэв энэ хугацаанд Нийтийн Танхимаас дээрх Засгийн газруудын альд нь ч итгэл хүлээлгэхгүй бол бүх нийтийн сонгууль болно.

Хэрэв Нийтийн танхим нь Ерөнхий сайдад итгэл үзүүлэхгүй, альтернатив Засгийн газарт итгэл үзүүлсэн тохиолдолд Ерөнхий сайд ажлаа өгнө.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

²⁶⁹Ц.Энхбаатар, С.Зүльфикар. Гадаад орнуудын төрийн байгуулалт. УБ., 2014 он.